

Монгол Улс


“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат “Төслийн мэдээ” сонин

Сэдэв:

- “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шат хэрэгжиж эхэллээ.
- Тэгш хамран сургах боловсролд чиглэсэн үйл ажиллагаа (1) Хөгжлийн бэрхшээлийг тогтоох, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээнд холбон зуучлах
- Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (2) Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчидтай ажиллах арга
- Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (3) Тэгш хамран сургадаг сургууль болъё!
- Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (4) Сургалтын орчинд шинэлэг санаа нэвтрүүлэе!
- Тэгш хамран сургах боловсрол гэж юу вэ?

2021 оны
7 дугаар сар
Дугаар 1

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шат хэрэгжиж эхэллээ.



Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал

Монголд бүх хүүхэд оршин суугаа газартаа ЕБС-д сурч боловсрох нөхцөл боломжоор хангагддаг болгох зорилгоор “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шат хэрэгжиж эхэллээ. Тус төслийн Англи нэрийн эхний үсгүүдийг ашигласан START2 гэдэг нэрээр хүмүүс хэдий мэддэг болжээ. 2019 он хүртэл хэрэгжсэн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн I шатанд, туршилтын аймаг дүүрэг, туршилтын сургуулиудад хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, ЕБС-ийн боловсролын үйлчилгээг сайжруулах зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулсан. Харин энэ удаагийн II шатны төслийн зорилго нь өмнөх шатанд хэрэгжсэн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх явдал билээ. Улмаар, цэцэрлэгт ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хамт сурч хүмүүжих боломжтой загварыг бий болгон үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр төлөвлөсөн. Цаашид бид Facebook болон цахим хуудастаа төслийн үйл ажиллагааны талаар, мөн “Төслийн мэдээ” сонинд тэгш хамран сургах боловсролд тустай мэдээлэл болон сайн жишээ туршлагаудаас нийтлэх болно.

Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (1) Хөгжлийн бэрхшээлийг тогтоох, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээнд холбон зуучлах

Бүх аймаг, дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” нь 16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох, байнгын асаргааг шийдвэрлэх, цэцэрлэг сургуульд хамрагдалтыг дэмжих чиг үүргийн дагуу сард 2 удаа ээлжит хуралдааныг зохион байгуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-т ялангуяа дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй байгаа хүүхдэд кейс хэлэлцүүлэг зохион байгуулна гэж тусгасан.

Кейс хэлэлцүүлгээр юуны өмнө “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)”-ын дагуу тухайн хүүхдийн нөхцөл байдлыг “Хувь хүний хүчин зүйл”, “Орчны хүчин зүйл”, “Бие махбодын бүтэц, үйл ажиллагаа”, “Үйлдэл чадвар”, “Нийгмийн оролцоо” зэрэг хүчин зүйлүүдэд ангилан хөгжлийн үнэлгээ хийдэг.

Хөгжлийн үнэлгээ хийснээр олон салбарын янз бүрийн мэргэжилтнүүд тухайн хүүхдэд тулгамдаж буй асуудлуудаар нэгдсэн нэг ойлголтод хүрч чадна (Баруун талын зураг). Дараа нь зорилтот хүүхдийн нийгмийн оролцоог дээшлүүлэхийн тулд, тухайлбал сургуульд хамруулах зорилт дэвшүүлж хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах ба уг төлөвлөгөөндөө тусгасан дэмжлэг, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.



Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (2) Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчидтай ажиллах арга

START2 төслийн хүрээнд цэцэрлэгийн багш нараас судалгаа авахад, “Хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийг хүлээн зөвшөөрдөггүй асран хамгаалагчдад хэрхэн дэмжлэг үзүүлэхээ мэддэггүй...”, “Гэрийнхэн нь хамтарч ажиллахгүй учраас хэцүү байдаг” гэх мэтчилэн асран хамгаалагчидтай ажиллахад хүндрэлтэй байдаг тухай дурджээ. Цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд, хүүхдийн амьдралын суурь орчин болох гэр бүлийнхний хамтын ажиллагаа, оролцоо зайлшгүй шаардлагатай болдог. Тиймээс багшаас асран хамгаалагчидтай ажиллах 3 зөвлөгөөг танилцуулъя. Та бүхэн ажилдаа туршиж үзэж болно.

1. Гэр бүлийн гишүүн бүрийн санаа бодлыг асууж мэдэх

Монголын айл өрхүүдэд, эцэг эх нь хоёулаа ажилладаг учраас хүүхэд өвөө эмээгийнхээ асрамжинд өсөж хүмүүжих явдал элбэг. Энэ нь “Хүүхдийг эх нь л өсгөх ёстой” гэж нэг талыг барихгүй сайн талтай боловч, эцэг эх нь хүүхдээ цэцэрлэгт оруулахыг хүсээд байхад, өвөө эмээ хоёр нь “Хүүгээ өрөвдөөд байх юм”, “Дээрэлхүүлчихэж магад” гээд цэцэрлэгт явуулахгүй байх зэргээр хүүхэд өсгөж хүмүүжүүлэх тал дээр гэр бүл дотор ойлголтын ялгаа, зөрүү хааяагүй гардаг. Мөн аутизм гэх мэт өнгөц хараад мэдэхийн аргагүй хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй үед “Манай хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байж магадгүй” гэж эцэг эх хоёрын хэн нэг нь санаа зовж байх тохиолдол ч гарна. Тиймээс хүүхэдтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүн бүрийн санаа бодол, сэтгэл зовоосон асуудлыг нь асууж мэдэхэд анхаараарай.



Хөгжлийн бэрхшээлийг нь анзаарч байв ч, хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг ойлгож хүлээн зөвшөөрнө гэдэг нь асран хамгаалагчийн хувьд маш хүнд асуудал байдаг. Тиймээс л асран хамгаалагчдын сэтгэл санааны байдлыг харгалзан ажиллах нь зүйтэй.

2. Гэр бүлийнхний хүсэж буйг анхааралтай сонсогч байх

Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүлээн авч, сургалтын үйл ажиллагааг нь төлөвлөх үед, “Хүүхдийн гэртээ байдаг байдал”, “Цэцэрлэгт явуулах хүсэлтэй эсэх” талаар тодорхой “хариулт өгөх” хандлага нь чухал. Гэвч гэрийнхний хүсэл нь тухайн хүүхдийн хөгжлийн одоогийн түвшингээс хол зөрүүтэй байх, хэт их зүйл хүсэх... зэрэг тохиолдол байж болно. Тийм үед, багш тухайн хүүхдийн ахиц хөгжил, давуу тал зэрэг эерэг талуудыг нь анзаарч, хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгөх, тосож авахаар ирэхэд эцэг эхэд нь сайн хэлж өгөх хэрэгтэй. Ийм байдлаар харилцан итгэлцэл бий болгосны дараа асран хамгаалагчтай цаг товлон уулзалт хийж болно. Хүүхдийнх нь хөгжлийн одоогийн түвшин болон гэр бүлийнхний хүссэн түвшин хүртэл яавал зохих тухай сайтар ярилцаж, хүүхдийн хөгжлийн нөхцөл байдалд тохирсон нийтлэг зорилтыг дэвшүүлнэ. Ингэж чадвал, хүүхдийг цэцэрлэгт сургаж хөгжүүлэх ажилд асран хамгаалагчийн туслалцааг авахад хялбар болно. Хэрэв хэт олон зүйл хүсээд байвал “Юуг хамгийн ихээр хүсэж байна” гэдэгт анхаарлаа хандуулдаг болтол, асран хамгаалагчийн санаж бодож буй зүйлүүдийг цэгцлэн ярилцаж байвал сайн.

Аливаа асран хамгаалагчтай өдөр бүр харилцдаг байх нь чухал. “Өнөөдөр хүү тань хүрмээ өөрөө өмссөн” гэх зэргээр жижиг ч хамаагүй ахиц өөрчлөлтийг нь хэлж өгөн хүүхэд нь өсөж хөгжиж байгаа, чармайж байгаад харилцан баярлаж урамшдаг тийм холбоог бий болгох нь зүйтэй.

3. “Болохгүй юм л бол болохгүй” гэдгийг хүүхэддээ хэлж өгөхийн чухлыг ойлгуулах

Зарим хүн, хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй учраас уурлахаараа юм шидлэх, цохиж зодох зэрэг үйлдлийг нь хүлцэн дуугүй өнгөрөөдөг. Харин хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран, тухайн хүүхдийн өсөлт хөгжил, ирээдүйг бодолцох үүднээс гэр бүлд нь шаардлагатай хүүхэдтэй харилцах аргыг зааж зөвлөх нь чухал. “Болохгүй юм л бол болохгүй” гэдгийг тодорхой хэлж өгөх, эсвэл “Дахиж юм шидэхгүйгээр ингээд хэлээрэй” гэх мэтчилэн биеэ авч явах, хүүхдэдээ хэлж ойлгуулах аргачлалыг тодорхой хэлж өгөх байдлаар хүүхэдтэйгээ зөв харилцах аргыг гэр бүлд нь сайн зааж зөвлөх нь зүйтэй. Мөн, хэл яриа ойлгох чадваргүй хүүхэд ч нүүрний хувирал, дууны өнгөөр том хүний ярианы агуулгыг барагцаалан ойлгож байдаг. Асран хамгаалагчидтай ойлголтоо нэгтгэх замаар хүүхдийг гэрт өсгөж хүмүүжүүлэх болон цэцэрлэгийн орчинд сургаж хөгжүүлэх ажилд хүүхдийн өөрийгөө хүндэтгэх чадварыг хөгжүүлэх боломжтой харилцах аргыг ашиглаарай.

Зарим цэцэрлэг эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөхийн тулд янз бүрээр ашиглах боломжтой өрөөг тохижуулсан байдаг. (Баянгол дүүргийн 161 дүгээр цэцэрлэг)



Та “Сургуулийн дэмжлэгийн баг” гэж сонссон уу? Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 5 дугаар сарын А/292 тоот тушаалд, сургууль бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сургуулийн дэмжлэгийн баг” байгуулж, сургуульдаа шаардлагатай дэмжлэгийг зохион байгуулах тухай заасан. “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийн гишүүнээр ажиллаж байгаа боловч юу хийх ёстойгоо сайн мэдэхгүй байгаа багш нар цөөнгүй байгаа боловч уу. Тиймээс энд “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийн тухай танилцуулъя.

Зорилго

Хөгжлийн бэрхшээл, сурлагын хоцрогдол, зан үйлийн асуудалтай хүүхэд гэх мэт боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг сургууль нийтээрээ дэмжиж ажиллах.



Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрхэн боловсруулах вэ?

Хэрхэн арга зүйгээ сайжруулахад суралцах вэ?



Анги удирдсан багш нь ганцаараа аргаа бардаг бус, багш нар бүгд бие биедээ тусалдаг тийм сургууль болцгооё!

Чиг үүрэг

- ◇ Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг тодорхойлох
- ◇ Тухайн хүүхдүүдийнхээ нөхцөл байдлыг судлах
- ◇ Хүүхэд нэг бүрт шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний талаар хэлэлцэж, хэзээ, хэн хариуцаж, хэрхэн зохион байгуулах талаар шийдвэр гаргах
- ◇ Дээрх төлөвлөгөөнийхөө биелэлтэд хяналт тавих
- ◇ Шаардлагатай тохиолдолд гадны мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах
- ◇ Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт болон эцэг эх, олон нийтэд чиглэсэн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах
- ◇ Сургууль дотроо кэйс хэлэлцүүлэг зохион байгуулж, багш нарыг нэгдсэн нэг ойлголттой болгох

Хичээлийн жилийн эхэнд дэмжлэгийн баг тухайн жилийнхээ үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тэрхүү төлөвлөгөөнийхөө дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж хэвших.

Гишүүд

- ◇ Сургуулийн захирал
- ◇ Сургалтын менежер
- ◇ Нийгмийн ажилтан
- ◇ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги удирдсан багш
- ◇ Бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч
- ◇ Дунд ангийн багш
- ◇ Сургуулийн эмч
- ◇ Баг/хорооны хариуцсан ажилтан
- ◇ Боловсролын газар/хэлтсийн хариуцсан мэргэжилтэн

Төлөвлөгөө, хуваариа хянан зохион байгуулах хүн томилчихвол, ажлаа зохион байгуулахад илүү хялбар болно.



Хөвсгөл аймгийн “Титэм” 2-р сургуулийн үйл ажиллагаа



- ◇ Нийгмийн ажилтан дэмжлэгийн багийн ахлагчаар ажиллан, хурал товлох, өрөө бэлтгэх ажлуудыг хариуцдаг.
- ◇ Хурлын өмнө, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн анги удирдсан багш нараас мэдээлэл цуглуулж, урьдчилсан жагсаалт гаргана. Багийн ахлагч багийн гишүүдэд хариуцах хүүхдүүдийг нь хуваарилан хүүхэд нэг бүрийн нөхцөл байдлыг тайлбарлаж өгнө. Эхний хурлыг бүх багш оролцох байдлаар зохион байгуулах, эсвэл урьдчилан мэдээлэл цуглуулах хэлбэрээр ч зохион байгуулж болно.
- ◇ Хүүхэд сургууль дээр болон ар гэртээ ямар байдалтай байдаг, ямар оноштой (Эмнэлэгт оношлуулсан бол) талаар мэдээлэл өгч, үзүүлэх дэмжлэгийнхээ агуулгыг тохирно.
- ◇ Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах эсэх тухай ч хэлэлцэнэ. (Боловсруулахдаа, асран хамгаалагч нь зөвшөөрсөн байх ёстой тул сургууль бие даан шийдэхгүй байхад анхаарах)

Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (4) Сургалтын орчинд шинэлэг санаа нэвтрүүлъя!

9 дүгээр сард шинэ хичээлийн жил эхэлнэ. Цар тахлын улмаас хүүхдүүд танхимд хичээллээгүй удсан хэдий ч, та бүхэн минь урьдын адил сургуулийн танхимд хүүхдүүдийн сэргэлэн цовоо дууг дахин сонсохыг хүсэж байгаа буй за. Танай ангид хичээлийн үед анхаарал нь хурдан сарнидаг, чанга дуу чимээг хэт эмзэг мэдэрдэг хүүхэд бий юу? Ангийн орчноо багахан өөрчлөх төдийд л хүүхдүүдэд хичээллэхэд нь хялбар болно. Шинэ хичээлийн жилийг угтан хэрэгжүүлэх боломжтой орчин бүрдүүлэлтийн зарим жишээнээс та бүхэндээ танилцуулъя.



Ангид үзүүлэн, чимэглэл их байх нь тохижилтыг сонирхолтой болгох хэдий ч хичээлийн үед хүүхдүүдийн анхаарал сарних шалтгаан болдог. Халхалж, далдлах боломжтой даавуун хөшиг бэлтгээд хичээлийн үед хааж байвал зүгээр.




Ангийн хаалганы босгонд хүүхдүүд бүдрэх тохиолдол их гардаг. Зурагт үзүүлсэнчлэн налуу хавтан байрлуулж өгвөл хүүхэд бүдрэх явдал цөөрч, тэргэнцэртэй хүүхэд төвөггүй орж гарах боломжтой болно.



Суудлын хуваарилалтаа өөрчлөөд үзээрэй. Хараа муутай эсвэл анхаарал сарнимтгай хүүхдийг дунд талын салааны хамгийн урд суулгавал зүгээр. Хичээлдээ тааруу, сурлагаар хоцрох гээд байдаг хүүхдийг урдаасаа хоёр дахь ширээнд суулгавал эргэн тойрныхоо хүүхдүүдийн үйлдлийг даган дуурайх боломжтой болно.



Юу хаана байгаа нь ганц харахад ойлгомжтой байх нь чухал. Бичгийн хэрэгсэл болон цүнхний тавиурын байрлалыг ойлгомжтой болгох үүднээс зурган болон үгэн карт ашиглаж болно.



Танд ямар санагдсан бэ? Жижиг сажиг өөрчлөлт, шинээр сэтгэх боломжтой зүйл олон байгаа биз. Хэрэв танай сургуульд орчноо сайжруулж тохижуулсан жишээ, шинэлэг санаа байвал, манай төслийн Facebook хуудас руу зургийг нь илгээгээрэй. Бид сайн жишээ болгон уншигчиддаа танилцуулах болно.

Тэгш хамран сургах боловсрол гэж юу вэ?

Тэгш хамран сургах боловсролын тухай сонсоод танд ямар нөхцөл байдал төсөөлөгддөг вэ? Баруун гар талын зурагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролд хамрагдаж буй 4 өөр хэлбэрийг үзүүлэв.


Зүүн дээд талын "Exclusion": Сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүлээж авахгүй тул боловсролд хамрагдаж чадахгүй байх.

Баруун дээд талын "Segregation": Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг өөр газарт бусад хүүхдүүдээс тусад нь боловсрол олгох.

Зүүн доод талын "Integration": Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд хамрагдсан ч сургууль дотор жижиг бүлэгт хуваан тусад нь боловсрол олгох.

Баруун доод талын "Inclusion": Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бусад хүүхдүүдтэй хамт шаардлагатай дэмжлэг аванга боловсролд хамрагдах.

Монгол Улс 2009 онд нэгдэн орсон "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц"-д "Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчлах үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана. Эл зорилгоор оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боломжит хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна" гэж заасан. Тус төсөл нь дээрх зураг дахь "Inclusion" буюу тэгш хамруулахыг зорилгоо болгон цэцэрлэг, сургуулийн холбогдох хүмүүстэй хамтран үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.



Source: ACTIVITY, SPORT, PLAY FOR THE INCLUSION OF REFUGEES IN EUROPE
<https://www.aspiresport.eu/>



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд билдинг, 505 тоот



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/029/index.html>



jicastart2@gmail.com



+976-80486690
+976-95937356

